



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 07 өдөр

Дугаар А/292

Мандалговь

Нэмэлт орлогыг зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 (а), Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.1 дэх заалт, Сангийн сайдын 74 дүгээр тушаалаар батлагдсан журмын 3.1.2 дах заалт, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.2, аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, төлөвлөгөөний 3.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2019 оны нэмэлт орлогын эх үүсвэр, зардлын зориулалтыг хавсралтаар баталсугай.


Хоёр. “Уяхан замбуу тивийн наран” урлагийн их наадмын зохион байгуулалтын үйл ажиллагаанд шаардагдах нэмэлт орлогын нийт 288,600,000 (хоёр зуун наян найман сая зургаан зуун мянга) төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн зарцуулахыг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

438190831



Аймгийн Засаг даргын 2019 оны 08 дугаар сарын
07-ны өдрийн 41 дүгээр захирамжийн хавсралт

ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО, ЗАРЛАГА

1	ОРЛОГО	Дүн
1.1	Хандив, тусламжийн орлого	85,000,000
1.2	Үйл ажиллагааны орлого (билет)	125,000,000
1.3	Авто машины зөвшөөрөл	40,000,000
1.4	Худалдаа, үйлчилгээний зөвшөөрөл	38,600,000
	Нийт дүн	288,600,000
2	ЗАРЛАГА	
2.1	Наадамд оролцогчдын байр, хоол, унааны зардал	40,000,000
2.2	Арга хэмжээний зохион байгуулалт, харуул хамгаалалтын зардал	68,600,000
2.3	Аж ахуйн үйлчилгээ, туслах материалын зардал	40,000,000
2.4	Эд, хогшилын зардал	60,000,000
2.5	Бусад зардал	50,000,000
2.6	Тээвэр шатахууны зардал	30,000,000
	Нийт дүн	288,600,000